



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 04 сарын 06 өдөр

Дугаар А/146

Арвайхээр

Мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, орчны
цэвэрлэгээ халдваргүйтгэлийг шуурхай зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3, "а", Мал, амьтны эрүүл мэндийн хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.4, Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны "Мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, орчны цэвэрлэгээ, ариутгал халдваргүйтгэлийн үйл ажиллагааг зохион байгуулах, отор нүүдлийн зорилготой мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, хяналт тавих тухай" 01 дүгээр албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Харьяалах нутагт дэвсгэртээ хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, мал эмнэлгийн ариун цэврийн халдваргүйтгэлийн ажлыг шуурхай зохион байгуулах, сэг зэмийг устгах, халдваргүйтгэлийн ажилд шаардагдах ажиллах хүч, унаа тээврийн болон бусад шаардлагатай зардлыг шийдвэрлэж, отор нүүдэл шилжилт хөдөлгөөн дамжин өнгөрөх чиглэл хугацааг тогтоох ажлыг зохион байгуулах, хэрэгжүүлэх, хяналт тавих ажлын хэсэг томилж, үүрэгжүүлэхийг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2. Аймгийн хэмжээнд мал, амьтны сэг зэмийг устгах орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх нэгдсэн төлөвлөгөө гарган, заавар удирдамжаар ханган, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн газрын Мал, амьтаны эрүүл мэндийн албны хяналтын улсын байцаагч (Ц.Төмөрбат) сумдын Мал эмнэлгийн тасагт үүрэг бологсугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн газар (А.Нямдаваа), сумдын Засаг дарга нар-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100315